



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/25

Алтай хот

**Комисс байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 41 дүгээр зүйл, 78 дугаар зүйлийн 78.2.6 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 268 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 98 дугаар тогтоол, Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураан авсан хөрөнгө, эд зүйлс, хэрэгслийг үнэлэх, худалдан борлуулах, устгах орон тооны бус зөвлөлийн 2021 оны 02 дугаар тогтоолын дагуу 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулах нээлттэй дуудлагын худалдааг эрхлэн явуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Өмчийн төлөөлөгч:Б.Золжаргал -(Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

Хөтлөгч: Р.Пүрэвдорж -(Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

Тэмдэглэл хөтлөгч:Б.Балдорж -(Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

2.Нээлттэй дуудлагын худалдааг хууль, журмын дагуу ил тод зохион байгуулж, дүнг холбогдох байгууллагад танилцуулж ажиллахыг комисс (Б.Золжаргал)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ